



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 241

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Завхан аймгийн Политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн 2017 оны 12 дугаар 07-ны өдрийн 07-07-027/190 дугаар дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, нийт 196,590,720.00 (нэг зуун ерэн зургаан сая таван зуун ерэн мянга долоон зуун хорь) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Завхан аймгийн Политехник коллежийн захирал Т.Рэнчинванжил нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг төрийн байгууллагын эзэмшилд хэвээр үлдээж, зориулалтын дагуу ашиглах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001376
14-г huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн
№111 дугаар тогтоолын хавсралт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ

№	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
Барилга, байгууламж						
1	Оюутны дотуур байр	1964-01-01	1	196,590,720.00	196,590,720.00	-
	Нийт дүн		1	196,590,720.00 (нэг зуун ерэн зургаан сая таван зуун ерэн мянга долоон зуун хорь)	196,590,720.00 (нэг зуун ерэн зургаан сая таван зуун ерэн мянга долоон зуун хорь)	